



АУДИТ  
БАТАЛГААЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭ

**ӨНДӨРХААН ХК-ИЙН  
2022 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР  
ТАСАЛБАР БОЛГОСОН**

A horizontal green band with a textured, halftone-like pattern. Inside the band, there is a faint, dark green silhouette of a city skyline with various buildings and a flag on a pole.

**АУДИТОРЫН  
ТАЙЛАН**

**АГУУЛГА****ХУУДАС**

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	3-4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
Тодруулга 1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9
Тодруулга 2 Бусад авлага	9
Тодруулга 3 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9-9
Тодруулга 4 Үндсэн хөрөнгө	9
Тодруулга 5 Дансны өглөг	9
Тодруулга 6 Татварын өр	10
Тодруулга 7 Бусад богино хугацаат өр төлбөр	10
Тодруулга 8 Бусад урт хугацаат өр төлбөр	10
Тодруулга 9 Хувийн өмч	10
Тодруулга 10 Хуримтлагдсан алдагдал	10
Тодруулга 11 Бусад орлого	10
Тодруулга 12 Ерөнхий ба удирдлагын зардал	11
Тодруулга 13 Санхүүгийн зардал	11
Тодруулга 14 Бусад зардал /ҮАБЗ/	11
Тодруулга 15 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	11
Тодруулга 16 Орлогын татварын зардал	11
Тодруулга 17 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага	12
Тодруулга 18 Балансын дараах үйл явдал	12

**БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

ҮҮСГЭН БАЙГУУЛАХ  
ШИЙДВЭР БА ГЭРЧИЛГЭЭ

Байгууллага нь 2007-10-25-ны өдөр УБЕГ-аас олгосон 2035987 тоот регистрийн дугаар бүхий 000133505 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг эзэмшдэг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 111,879 ширхэг энгийн хувьцааг Монгол Улсын иргэн Э.Пүрэвсүрэн 32.00%, Б.Ашхүү 32.00%, Б.Батаа 17,62%, Бусад хувьцаа эзэмшигч 18.38%-ийг эзэмшиж байна. Нийт хувьцаа эзэмшигчид 307

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

О.Амарболд

АЛБАН ХАЯГ

Хэнтий, Хэрлэн, 5-р баг, Өндөрхаан, 01

ХАРИЛЦАГЧ БАНК

Хас банк

АУДИТОР

Мэжик Консалтинг Аудит ХХК  
Мэргэшсэн Нягтлан Бодогчид  
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, Манлайбаатар  
Дамдинсүрэнгийн гудамж, UB tower, 15 давхарт 1502 тоот



**2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон  
Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах  
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү мэдэгдэл нь " Дунд Хөөн ХК " Хувьцаат Компанийн ("Компани" гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт(СТОУС)-уудын дагуу үнэ зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журамд нийцүүлэн үнэн зөв, шударгаар илэрхийлсэн байх ёстой.

**Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээдэг.**

**Үүнд:**

- Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэслэлтэй, хянамгай шийдвэр гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг зөрүү буюу өөрчлөлт байгаа бол түүнийг санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- Компани ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах төсөөлөлд үндэслэж бэлтгэх

**Удирдлага нь мөн түүнчлэн,**

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компани санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэ зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.



Захирал

Огноо:

2023.03.15

О. Сагсан

Ерөнхий Нягтлан Бодогч



ӨНДӨРХААН ХК-ийн  
хувьцаа эзэмшигчид

**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
25-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн  
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.  
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn  
Вэб хуудас: www.magicgroup.mn

2023-05-15 дугаар 23-УБ.04.99

танай \_\_\_\_\_-ны дугаар \_\_\_\_\_-т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид Өндөрхаан ХК ('Компани' гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал гараагүй гэж тодорхойлж байна.

### Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

### **Бусад асуудал**

Өндөрхаан ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад өөр аудитор аудит хийсэн бөгөөд Эерэг дүгнэлт илэрхийлсэн байна. Бид компанийн 2021 оны санхүүгийн тайланд аудит, нягтлах ажил эсвэл баталгаажуулах горим хэрэгжүүлэхээр тохироогүй тул 2021 оны санхүүгийн тайланд бүхэлд нь ямар нэг баталгаа гаргах эсвэл санал дүгнэлт илэрхийлээгүй болно.

### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.МӨНХБАЯР  
МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ, ПАРТНЕР  
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК  
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

2023 оны 03 дугаар сарын 15

(Мянган төгрөг)

ХӨРӨНГӨ	Тод	2021-12-31	2022-12-31
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1	500.7	5,973.7
Татвар, НДШ-ийн авлага		142.6	142.6
Бусад авлага	2	2,833.2	1,805.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3	100,504.0	1,587.9
		<b>103,980.4</b>	<b>9,509.9</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
Үндсэн хөрөнгө	4	3,499.9	11,142.6
		<b>3,499.9</b>	<b>11,142.6</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>107,480.3</b>	<b>20,652.5</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны өглөг	5	136,489.1	3,079.5
Татварын өр	6	1,300.4	3,893.9
Бусад богино хугацаат өр төлбөр	7	1,569.5	12,038.0
		<b>139,359.1</b>	<b>19,011.4</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Бусад урт хугацаат өр төлбөр	8	1,930.4	-
		<b>1,930.4</b>	<b>-</b>
<b>ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>141,289.4</b>	<b>19,011.4</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ:</b>			
Хувийн өмч	9	11,187.9	11,187.9
Хуримтлагдсан алдагдал	10	(44,997.0)	(9,546.8)
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>(33,809.1)</b>	<b>1,641.1</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>107,480.3</b>	<b>20,652.5</b>

Нэмэлт Тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**2022-12-31-ний байдлаар:**

Нийт хөрөнгийн 46.05 хувийг эргэлтийн хөрөнгө, 53.95 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 80.78 хувиар буурсан байна.

Нийт хөрөнгөд эзлэх эзний өмч 7.95 хувь, өр төлбөр 92.05 хувь байна.



(Мянган төгрөг)

	Тод	2021-12-31	2022-12-31
Борлуулалтын орлого		-	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		-	-
<b>Нийт ашиг</b>		-	-
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого		-	-
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	11	37,951.8	80,010.4
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(32,944.7)	(382,847.8)
Санхүүгийн зардал	13	-	(8,000.0)
Бусад зардал /ҮАБЗ/	14	(34,330.0)	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15	-	349,696.1
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)		-	-
<b>Нийт</b>		<b>(29,322.9)</b>	<b>38,858.7</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/</b>		<b>(29,322.9)</b>	<b>38,858.7</b>
Орлогын татварын зардал	16	(500.7)	(3,885.9)
<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>		<b>(29,823.6)</b>	<b>34,972.8</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг		-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>		<b>(29,823.6)</b>	<b>34,972.8</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Орлогын нийт дүн</b>		<b>(29,823.6)</b>	<b>34,972.8</b>

Нэмэлт Тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**2022-12-31-ний байдлаар:**

- Цэвэр ашиг 64,796.4 мянган төгрөгөөр өссөн байна.
- Цэвэр алдагдал 34,972.80 мянган төгрөг байна.



(Мянган төгрөг)

	Өмч	Эздийн өмч бусад хэсэг	Хуримтлагдсан алдагдал	Нийт дүн
<b>2021-12-31</b>	<b>11,187.9</b>	-	<b>(44,997.0)</b>	<b>(33,809.1)</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			477.4	<b>477.4</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	11,187.9	-	(44,519.6)	<b>(33,331.7)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			34,972.8	<b>34,972.8</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-		-
Өмчид гарсан өөрчлөлт		-		-
Зарласан ногдол ашиг		-		-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-		-
<b>2022-12-31</b>	<b>11,187.9</b>	-	<b>(9,546.8)</b>	<b>1,641.1</b>

Нэмэлт Тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**2022-12-31-ний байдлаар:**

- Эзний өмч өмнөх онтой харьцуулахад 35,450.2 мянган төгрөгөөр өссөн байна.
- Нийт хөрөнгөд эзлэх эзний өмч 7.95 хувь, өр төлбөр 92.05 хувь байна.
- Нийт эзний өмчийн 2,131.05 хувийг тайлант үеийн цэвэр ашиг эзэлж байна.
- Эзний өмчийн бусад хэсэг багананд бусад өмчийн дансдуудыг нэгтгэж харуулав.

(Мянган төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2021-12-31	2022-12-31
<b>1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1 Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
.....	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
1.2 Мөнгөн зарлагын дүн (-)	<b>12,543.6</b>	<b>256,746.2</b>
Ажилчдад төлсөн	5,824.6	151,493.5
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,099.7	46,075.9
Бараа материал худалдан авахад төлсөн	-	63.0
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	658.0
Хүүний төлбөрт төлсөн	-	3,079.5
Татварын байгууллагад төлсөн	-	18,429.0
Даатгалын төлбөрт төлсөн	-	2,700.0
Бусад мөнгөн зарлага	4,619.3	34,247.2
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(12,543.6)</b>	<b>(256,746.2)</b>
<b>2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1 Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
.....	-	-
2.2 Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>51.5</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	39.0
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>12.5</b>
<b>3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1 Мөнгөн орлогын дүн (+)	13,000.0	<b>277,887.8</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	13,000.0	277,400.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	487.8
Төрөл бүрийн хандив	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>15,617.0</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	8,265.2
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	7,300.5
Хувьцаа буцаан авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	51.4
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>13,000.0</b>	<b>262,270.7</b>
4 Вальютын ханшын зөрүү	-	-
<b>4.1 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>456.4</b>	<b>5,473.1</b>
<b>5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>44.3</b>	<b>500.7</b>
<b>6 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>500.7</b>	<b>5,973.7</b>